



ТЭЭВЭР, 2020 оны эхний 4 сарын байдлаар



Агаарын тээвэр

	2019 I-IV	2020* I-IV	
Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	401.1	240.1	
Тээсэн ачаа, тонн	1727.8	1194.3	
Тээврийн орлого, сая төгрөг	123 079.3	58 614.1	



Төмөр замын тээвэр

	2019 I-IV	2020* I-IV	
Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	763.9	556.1	
Тээсэн ачаа, мян.тонн	8 715.4	9 510.2	
Тээврийн орлого, сая төгрөг	219 525.5	235 866.5	


*-Урьдчилсан гүйцэтгэлээр



ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 4 сард 9.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 794.8 (9.1%) мянган тонноор өсжээ.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачаа экспортын ачаа 900.3 (28.6%) мянган тонн, импортын ачаа 51.2 (6.0%) тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2020 оны 4 дүгээр сард 2.4 сая тонн болж, өмнөх сараас 63.7 (2.7%) мянган тонноор өсжээ.

Төмөр замаар тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эхний 4 сараар

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV *
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	90.0	88.4	90.4
Барилгын материал	4.4	5.4	4.0
Мод, модон материал	0.5	0.5	0.4
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	0.9	0.8
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	0.8	1.6	0.9
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	0.7	1.0	1.4
Бусад	2.7	2.2	2.1

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 4 сард тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 90.4 хувь, барилгын материал 4.0 хувь, хар төмөр 1.4 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 0.9 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.8 хувь, мод модон материал 0.4 хувь болон бусад бүтээгдэхүүн 2.1 хувийг эзэлж байна.

Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны эхний 4 сард 556.1 (давхардсан тоо) мянга болж өмнөх оны мөн үеэс 207.8 (27.2%) мянган хүнээр буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид буурахад орон нутгийн зорчигчид 194.1 (26.3%) мянган хүнээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны 4 дүгээр сард 111.3 (давхардсан тоо) мянга болж, нь өмнөх сараас 12.3 (12.4%) мянган хүнээр өссөн байна.


Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 4 сард 235.9 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 16.3 (7.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны 4 дүгээр сард өмнөх сараас 2.9 (4.9%) тэрбум төгрөгөөр өсөж, 61.8 тэрбум төгрөг болжээ.

АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2020 оны эхний 4 сард 1.2 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 533.5 (30.9%) тонноор буурсан байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар




Агаарын тээврээр 2020 оны эхний 4 сард дотоодод 28.3 (2.4%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 4.0 (16.7%) тонноор өссөн байна.

Харин олон улсад тээсэн ачаа 1.2 (97.6%) мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 537.6 (31.6%) тонноор буурчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 4 дүгээр сард 111.0 тонн болж, өмнөх сараас 63.8 (36.5%) тонноор буурсан байна.

Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр зорчигчид 2020 оны эхний 4 сард 240.1 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 161.0 (40.1%) мянган хүнээр буурсан байна. Агаарын тээврээр зорчигчид 2020 оны 4 дүгээр сард мянга болж өмнөх оны мөн үеэс 8.8 (26.4) мянган хүнээр бага байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2020 оны эхний 4 сард 107.6 (44.8%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 20.3 (15.8%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Чойбалсан чиглэлийн зорчигчид 74.8 хувь, Баян-Өлгий чиглэлийн зорчигчид 33.2 хувь, Оюутолгой чиглэлийн зорчигчид 16.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний 4 сард 132.5 (55.2%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 140.7 (51.5%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 75.8 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 63.7 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 67.1 хувь, Улаанбаатар-Москва чиглэлийн зорчигчид 42.5 хувь, Улаанбаатар-Сүүл чиглэлийн зорчигчид 40.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны 4 дүгээр сард өмнөх сараас 380.0 (6.1%) сая төгрөгөөр өсөж 6.7 тэрбум төгрөг болсон байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний 4 сард 58.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 64.5 (52.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.